



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

**2015 оны 02 сарын 12 өдөр**

**Дугаар 33**

**““Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 17 дугаар тогтоолын “эдийн засгийн” гэснийг, мөн тогтоолын 1 дэх заалтын “худалдаа, үйлдвэрлэл, аялал, жуулчлалын үйл ажиллагаа явуулах” гэснийг тус тус хассугай.

2.Энэ тогтоолыг Чөлөөт бүсийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**ДАРГА**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**

**З.ЭНХБОЛД**

---